



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 08 дугаар
сарын 31-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийх тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн 06 ээлжит хуралдааны тэмдэглэлээс:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийх тухай танилцуулга

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тодотголын төслийг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлага танилцуулсны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд асуулт тавьж, санал дэвшүүлэн, тодотголын төслийг Аудитын хороогоор хянуулж, дүгнэлт гаргуулахаар тогтов.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тодотголын төслийг үндэслэлтэй боловсруулж, тайлбарын хамт Аудитын хороонд 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэхийг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал П.Ганхүүд, компанийн 2022 оны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тодотголыг хянан, дүгнэлт гарган, Төлөөлөн удирдах зөвлөлийн 9 дүгээр сарын ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо (Д.Нар-Од)-нд үүрэг болгов.

2. Компанийн эрсдлийн удирдлага, хяналтын үйл ажиллагааны тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн 10 дугаар сарын ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал П.Ганхүүд даалгав.

ДАРГА



БАРТУР